



220.

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 69

Есөнбулаг сум

**Зорилтот бүлгийн өрхөд хоол тэжээлийн
дэмжлэг үзүүлэх аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.9, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 22.2.1 дэх заалтууд, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 447 дугаар тогтоолын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангах, орлого багатай өрхийн хүн амын хоол, тэжээлийн дутлыг бууруулах зорилгоор “Зорилтот бүлгийн өрхөд хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг хагас, бүтэн жилээр гарган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

0300305



ЗОРИЛТОТ БҮЛГИЙН ӨРХӨД ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Засгийн газраас хүн амын хоол тэжээлийн дутлыг бууруулах асуудалд анхаарч ажилласны үр дүнд Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод “Хоол тэжээлийн дуталтай хүн амын тоог 2015 он гэхэд 1990 онтой харьцуулахад 6 дахин бууруулах” зорилтыг бүрэн хангасан байна. Үндэсний статистикийн хорооноос 2013 онд хийсэн судалгаагаар манай улсын 5 хүртэлх насны хүүхдийн 10,8 хувь нь өсөлтийн хоцролтой, 1,6 хувь нь тураалтай, 1,0 хувь нь туранхай, түүнчлэн нийт хүн амын амин дэм, бичил бодисын дутал 10 жилийн өмнөх түвшинд хэвээр байгааг тогтоожээ. Уг судалгаанаас үзэхэд манай улс хүн амын хоол тэжээлийн дутлын хувьд дээр дурдсан зорилтод бүрэн хүрсэн хэдий ч цаашид хоол тэжээлийн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын найрлага, хэмжээнд анхаарал хандуулж “эрүүл-шим тэжээлт хоол хүнс” хэрэглэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Манай улс махнаас бусад хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг импортоор авч хэрэгцээгээ хангаж байгаа нь хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөд хамгийн их нөлөөлж байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд нэг хүнд ногдох үндсэн нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ өсч байгаа хэдий ч хүн амын ажил эрхлэлт, амьжиргааны түвшин, тэдний орлого, хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт харилцан адилгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь айл өрх болон хувь хүмүүст сөрөг нөлөө үзүүлж байгаа бөгөөд үүнд хамгийн их өртөж байгаа нь ядуу өрхийн жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 5 хүртэлх насны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, байнгын асаргаа шаардлагатай асран хамгаалах хүнгүй ахмад настан байна. Түүнчлэн орон гэргүй, ажилгүй, төв суурин газар шилжин суурьшсаны улмаас нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжгүй болсон иргэд, ядуу иргэд үнийн өсөлтөд хамгийн ихээр өртөж байна.

Иймд хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс тэднийг хамгаалж, нийгмийн баталгаат байдлыг хангах зорилгоор “Нийгмийн эмзэг хэсэг буюу Зорилтод бүлгийн өрхөд хоол, тэжээлийн дэмжлэг үзүүлэх дэд хөтөлбөр” /цаашид “дэд хөтөлбөр” гэх/ хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Хоёр. Дэд хөтөлбөрийн зорилго, хугацаа, санхүүжилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

2.1.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь нийгмийн халамж, дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэдийг хоол тэжээлийн дутлын эрсдэлээс хамгаалж, хэрэгцээг хангахад оршино.

2.2. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

2.2.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

2.3.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

2.3.1.1. улс, орон нутгийн төсөв;

2.3.1.2. хандивлагч орон болон олон улсын байгууллагын хандив, зээл, тусламж;

2.3.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

2.3.1.4. бусад эх үүсвэр.

Гурав. Дэд хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

3.1. Зорилт нэг. Орлого багатай иргэний хүнсний хэрэглээний гол бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх.

3.1.1. Өрхийн амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой өрх, иргэнд хүнсний хэрэглээний гол нэрийн бүтээгдэхүүнийг хүн амын дараах бүлэгт жилд 1 удаа олгоно.

а/ Тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан болон байнгын асаргаа шаардлагатай ахмад настан;

б/ Асран хамгаалах хүнгүй, ганц бие, хөдөлмөрийн чадвараа 70 болон түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

в/ Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхэд;

г/ Бүрэн хараагүй, сэтгэцийн өвчтэй 0-18 насны хүүхэд.

3.2. Зорилт хоёр. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд байгаа 0-5 насны хүүхдэд хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх.

3.2.1. Өрхийн амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой өрхийн 0-5 насны дараах хүүхдэд жилд 1 удаа хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх

а/ "Өсөлтийн хоцрол"-той нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон хүүхэд;

б/ "Тураал"-тай нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон хүүхэд;

в/ "Туранхай" нь мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон хүүхэд.

3.3. Зорилт гурав. Нийгмийн халамж дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн, иргэнд хүнсний эрүүл ахуйн талаар мэдлэг мэдээлэл олгох.

3.3.1 Нийгмийн халамж дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн

гишүүн-иргэнд хүнсний эрүүл ахуйн мэдээлэл зөвлөгөө өгөх

а/ 0-5 насны хүүхэдтэй эхэд "эхийн сүүгээр дагнан хооллолт"-ын талаар сурталчлан таниулах;

б/ Өрхийн амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой өрх, иргэнд эрүүл хоололт"-ын талаар сургалт сурталчилгаа хийх;

в/ Өрхийн амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой өрх, иргэн болон 0-5 насны хүүхэд эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулах.

Дөрөв.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1.Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар хариуцан зохион байгуулна.

4.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, биелэлтэд нь хяналт тавьж ажиллах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

Тав.Хөтөлбөрийн үр дүн, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт

5.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

5.1.1.эрүүл, аюулгүй хооллолтын байдал сайжирч, хоол тэжээлээс хамааралтай өвчин, эмгэгийн тархалт буурна;

5.1.2.өрхийн амьжиргааны түвшингөөс доогуур орлоготой өрхийн гишүүн иргэний хүнсний хангамж нэмэгдсэн байна;

5.1.3.зорилтот бүлэгт чиглэсэн бодлого тодорхойлогдож, хэрэгжүүлэх механизмийг бүрдүүлсэн байна;

5.1.4.хүнс, хоол тэжээлийн тандалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, судалгааны чадавх бэхжиж, нотолгоонд суурилсан бодлого, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

5.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг жил бүр хийнэ.

5.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ.

-----ooOoo-----